



**“НАЙНГИ” ХХК**

Дорнод аймаг, Хэрлэн сум,  
6-р баг, “Найнги” өөрийн байр  
Утас: 70583094  
И-мэйл: [info@naingi.mn](mailto:info@naingi.mn)

**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ  
ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ-д**

Огноо 2023.01.04 № 23/01

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Төлөвлөгөө батлуулах тухай

Манай компани нь Дорнод аймгийн Хэрлэн сумын 8 дугаар баг, Баянт сумын 4 дүгээр /Хотонт/ багийн нутаг дэвсгэр Адуунчулууны орд газарт 1 тусгай зөвшөөрөлтэй талбайд 1998 оноос эхлэн ашиглалтын үйл ажиллагаа яв “Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-д эрчим хүчний нүүрс болон 6 иргэн аж ахуйн нэгж байгууллагын нүүрсний хэрэгцээг ханган ажиллаж байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны А/618 тоот тушаа батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, батлах, тайлагнах журам”-ын дагуу уг ордын 2023 оны байгаль о менежментийн төлөвлөгөөг боловсрууллаа.

Иймд нүүрсний уурхайн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө төслийг зохих хууль журмын дагуу баталж өгнө үү.

Хавсралт 67 хуудас

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Ш.БЯМБАСҮРЭН



ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛГЭЧ АГЕНТЛАГ  
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ  
ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

21075, Чойбалсан, Дорнод аймаг,  
Утас/Факс: 7058-3529

2023.01.04 № 03

танай -ны № -т

Төлөвлөгөөнд тусгах тухай

Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас орон нутгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газарт ирүүлсэн чиглэлийн дагуу танай аж ахуйн нэгжийн 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төслийг хянаж үзлээ. Үүнд:

1.Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөөний хүснэгтийн 2-д байгаа “Галын аюулаас урьдчилан сэргийлэх талаар дүрэм, журам боловсруулж” гэсэн байна. Танай аж ахуйн нэгж энэ дүрэм, журмыг шинэчлэн боловсруулж болон өмнө байгаа болохоор шинээр боловсруулан мөрдөж ажиллах гэж байгаа эсэхийг тодорхой болгон тусгах.

2.Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу агаар, хөрс, ус, ургамлын нөмрөгт хийх шинжилгээний хариунд тулгуурлан тайлант онд мониторинг хийх боломжийг бүрдүүлэн шинжилгээг улирал бүр нэг удаа авч байхаар тусгах.

3.Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөнд:

3.1.Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлагдсан даруйд орон нутгийн байгаль орчны асуудал хариуцсан төрийн байгууллага, сумын Засаг дарга нарт хүргэх, тайлагнах ажлыг тусгах.

3.2.Байгаль орчны мэргэжилтэн техникийн нөхөн сэргээлтийн ажлын явц, үр дүнд байнгын хяналт тавих үүргийг тодорхойлон тусгах.

3.3.Орчны хяналт шинжилгээний дээж авах ажилд хөндлөнгийн хяналтаар сумын байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагчийг байнга оролцуулах ажлыг тусгах.

5.Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний хүснэгтийн 4-д “БОМТ-ний биелэлтийг дүгнүүлэх талаар” гэсэн ажлын хугацааг 11 дүгээр сарын 01-ний өдрөөс 30 гэж өөрчлөн тусгах.

Иймд 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд дээрх ажлуудыг бүрэн тусган хэрэгжүүлэн ажиллана уу.

ДАРГА А.ГАНТУЛГА



80522432



БАТЛАВ:

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН  
ЯАМНЫ ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧИН, БАЙГАЛИЙН  
НӨӨЦИЙН УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГА

.....А.ЭНХБАТ

БАТЛАВ:

ЗӨВШӨӨРЧ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН:

“НАЙНГИ” ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

.....Ш.БЯМБАСҮРЭН



**ДОРНОД АЙМГИЙН ХЭРЛЭН, БАЯНТҮМЭН  
СУМДЫН НУТАГТ ОРШИХ АДУУНЧУЛУУНЫ НҮҮРСНИЙ  
УУРХАЙН 2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ  
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Тусгай зөвшөөрлийн дугаар: MV-1364A

Регистрийн дугаар: 2010895

**ХЯНАСАН:**

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны

Хүрээлэн буй орчин байгалийн нөөцийн удирдлагын газрын

ахлах шинжээч:..... Б.Буяннэмэх

**БОЛОВСРУУЛСАН:**

“Найнги” ХХК-ийн Байгаль орчны мэргэжилтэн ..... Э.Төмөрбаатар

2022 он

## Агуулга

1. Төслийн танилцуулга	2
2. Төсөл хэрэгжиж буй нутгийн байгаль орчин, нийгэм эдийн засгийн төлөв байдлын товч танилцуулга	6
3. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт	9
4. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ	13
5. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	14
6. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	19
6.1 Техникийн нөхөн сэргээлт	19
6.2 Биологийн нөхөн сэргээлт	25
7. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	27
8. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	31
9. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	32
10. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	33
11. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	35
12. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	36
12.1 Агаар орчны бохирдол	
12.2 Хөрсний бохирдол	
12.3 Усны бохирдол	
12.4 Ургамлын мониторинг	
12.5 Амьтны мониторинг	
13. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	39
14. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	42



## 1. Төслийн танилцуулга


### 1.1 Уурхайн үйл ажиллагаа явагдаж буй газрын засаг, захиргааны харьяалал

Адуунчулууны хүрэн нүүрсний ордын “Найнги” ХХК-ийн эзэмшдэг 1364 ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй 74.08 га талбай нь Дорнод аймгийн Хэрлэн сумын 8-р баг, Баянтүмэн сумын 4-р багийн нутаг дэвсгэрийг дамнан өмнөд уртрагийн  $114^{\circ} 32'$ , хойд өргөргийн  $48^{\circ} 07'$ -ийн солбицолд оршдог. Тусгай зөвшөөрөлтэй талбайн 21.08 га нь Хэрлэн сумын 8 дугаар багт, 53.0 га нь Баянтүмэн 4 дүгээр багт тус тус хамаардаг.

Төсөл хэрэгжих талбай Улаанбаатар хотоос 665 км-ийн, Чойбалсан хотын төвөөс 8 км-ийн, УБТЗ-ийн Баянтүмэн өртөөнөөс 2 км-ийн зайд байрлана.

**Тусгай зөвшөөрөлтэй талбайн солбицол:**

№	Уртраг	Өргөрөг
1	$114^{\circ} 32' 32.33$	$48^{\circ} 07' 32.92$
2	$114^{\circ} 31' 52.34$	$48^{\circ} 07' 32.92$
3	$114^{\circ} 31' 52.34$	$48^{\circ} 08' 01.92$
4	$114^{\circ} 32' 32.33$	$48^{\circ} 08' 01.92$





## 1.2 Ангиалал:

Адуунчулууны орд нь нүүрсний ил уурхайн төсөл бөгөөд MV-1364A дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайг “Найнги” ХХК-ийн эзэмшдэг. Энэхүү талбай нь одоогийн Адуунчулууны ил уурхайн ашиглалт явуулсан талбай ба зарим ашиглагдаагүй талбайг хамарч байгаа болно.

Манай компани “Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨҮГ-ийн Дулааны цахилгаан станцын эрчим хүчний нүүрс, болон бусад иргэн аж ахуйн нэгж байгууллагын нүүрсний хэрэгцээг бүрэн хангадаг.

2023 онд 750 мян.м<sup>3</sup> хөрс хуулахаар төлөвлөсөн бөгөөд үүний дагуу 1 дүгээр улиралд багтаан бүх машин, механизмын их засвар болон урсгал засварын ажлыг хийж гүйцэтгэнэ. Ингэснээр 420 мян.тн нүүрс олборлох бөгөөд энэ нь 2024 оны төлөвлөсөн 380 мян.тн нүүрсний нөөцийг бэлтгэх юм.

Ажлын үед тавих зааварчилгааг мөрдлөг болгон дараах төрлийн ажлуудыг төлөвлөгөөт онд хийж гүйцэтгэнэ. Үүнд:

### 1.2.1 Уулын бэлтгэл ажил

Ордын хөрсний чулуулгийг нь элс, хайрга, сул цементлэгдсэн элсэн чулуу, зарим үед тохиолдох шавраас бүрэлдэх бөгөөд хайгуул хийгдсэн талбайд жигд хэмжээгээр тархсан байна.

Адуунчулууны уурхайн хөрсний чулуулгийн бат бөхийн коэффициент  $f < 4$  байх тул нүүрс болон хөрсний дийлэнх хувийг шууд ухаж ачна. Өмнөх жилүүдэд хүйтний саруудад улирлын чанартай хөлдсөн болон хатуу шаварлаг хөрсний давхаргыг ухаж ачихад бэлтгэсэн.

Ашиглалтын явцад хатуу шаврын үе шувтарч нимгэрсэн бөгөөд уг давхарга хөрсний дээд доголлуудад 2 хүртэлх метрийн зузаантай зарим үед тохиолддог. Хөрсний чулуулаг нь хүйтний улиралд дунджаар 3 м гүн хөлддөг.

### 1.2.2 Хөрс хуулалт, овоолго байгуулалт

Хөрс хуулах ажил нь Чулуулгийг бэлтгэх, Ухаж ачих, Тээвэрлэх гэсэн үндсэн технологитой байна. Хөрс хуулалтын ажлыг 5 дугаар сараас эхлүүлээд 11 дүгээр сарын 15-ны өмнө дуусгахаар төлөвлөсөн. Шимт хөрс түрэх ажлыг 4 дүгээр сард хийж гүйцэтгэх бөгөөд түрсэн хөрсөө тусгай зөвшөөрөлтэй талбайн баруун хойд



хэсэгт овоолго үүсгэн хураана. Хөрсний 3 доголд ажиллах бөгөөд 760 дугаар түвшинд 270 мян.м<sup>3</sup>, 750 дугаар түвшинд 250 мян.м<sup>3</sup>, 740 дүгээр түвшинд 230 мян.м<sup>3</sup> хөрс тус тус хуулна. Хөрс хуулах ажлын нэг ээлж нь 8 цаг байх бөгөөд хоногт 2 ээлжээр 16 цаг ажиллана. 2023 онд тэсэлгээний ажил хийгдэхгүй.

Хүснэгт №1 Хөрс хуулах ажлын төлөвлөгөө

N	Түвшин	Хэмжих нэгж	2023	II-улирал				III-улирал				IV-улирал			
				4 сар	5 сар	6 сар	дүн	7 сар	8 сар	9 сар	дүн	10 сар	11 сар	12 сар	дүн
1	Гор-760	мян. м <sup>3</sup>	270	-	100	110	210	60	-	-	60	-	-	-	-
2	Гор-750	мян. м <sup>3</sup>	250	-	-	-	-	50	100	100	250	-	-	-	-
3	Гор-740	мян. м <sup>3</sup>	230	-	-	-	-	-	-	-	-	130	100	-	230
	Дүн	мян. м <sup>3</sup>	750	-	100	110	210	110	100	100	310	-	-	-	230

Хөрс хуулалтын ажлын улмаас гарах хөрсний чулуулгийг уурхайн ашиглагдсан хоосон орон зайд дотоод овоолго үүсгэн хураана. Овоолгыг уурхайн зүүн урд болон зүүн талын хоосон орон зайд байгуулж дүүргэлт хийхээр төлөвлөсөн. Хөрсний мөргөцгөөс дотоод овоолго хүртэл 1.25-1.5 км-ийн зайтай байх бөгөөд 50 тонны дампыг нь ачаатай үедээ 15-20 км/цагийн хурдтай, хоосон үедээ 20-25 км/цагийн хурдтай байна.

#### 1.4 Аж ахуйн нэгжийн техникийн мэдээлэл:

“Найнг” ХХК 750 мян.м<sup>3</sup> хөрс, 380 мян.тн нүүрс нийт 1,069.3 мян.м<sup>3</sup> уулын цулын ажил гүйцэтгэхэд хэрэглэгдэх машин техник

Хүснэгт №3 Машин техникийн бэлэн байдал

Д/д	Материалын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг
1	Foton 480E гидро-экскаватор	ш	1
2	XCMG-900D гидро-экскаватор	ш	1
3	Бульдозер TY-230	ш	1
4	Утгуурт ачигч Foton-ivol	ш	2
5	Автосамосвал-Foton Auman	ш	5
6	Дамп-XCMG	ш	4
7	Hino-Ranger крантрак	ш	1
8	Түлшний цистерн	ш	1
9	Nissan Caravan	ш	1
10	Усны машин	ш	2

1.3 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал

Хүснэгт №2 Зардлын задаргаа

№	Хийгдэх ажил	Зардал төг
1.1	Нөлөөллөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ /технологийн зөв шийдэл/	1,271,800
1.2	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	
2.1	Техникийн нөхөн сэргээлт	18.061.200
2.2	Биологийн нөхөн сэргээлт	9,840.000
3	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ	16,727.000
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ	-
5	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээ	-
6	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	-
7	Ахуйн хог хаягдал	1,200.000
8	Тухайн жилийн орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрийн нийт төсөв	800.000
9	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалт	1,200.000
10	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах	900.000
	<b>Дүн</b>	<b>50.000.000</b>



## 2. Төсөл хэрэгжиж буй нутгийн байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч танилцуулга

### 2.1 Байгаль орчин

2.1.1 **Уул зүй:** Адуунчулууны ордын район нь зүүн урагш ба хойшоо аажмаар намссан сул дов толгодорхог тал бөгөөд хүрээлэн байгаа хөндийнүүдэд Баяннуур, Цайдам нуур, Шүүтийн тойром, зэрэг давст нуурууд байдаг. Эдгээр нууруудын усны түвшиний үнэлэхүй өндөр 713,0-738м байна. Орд нь доворхог налуу гадаргуутай.

2.1.2 **Уур амьсгал:** Уг район нь эх газрын эрс тэс уур амьсгалтайгаас гадна агаарын их хуурайшилттай тул хур тунадас бага унадаг. Өвөлдөө хүйтэн, салхитай хурд бага, агаарын чийгшилт харьцангуй их, агаар мандлын доод хэсэгт температурын инверс тогтдог зэрэг онцлогтой. Цаг уурын эрс өөрчилттэй. Агаарын температур хоногийн болон улирлын хэлбэлзэл ихтэй байдаг. Өвлийн улиралд нь хөрс нь 3 метр хүртэл хөлддөг. Адуунчулууны орд газарт 144.0-315.9 мм хур тунадас унадаг бөгөөд 7,8 сард хамгийн их хур тунадастай. Жилийн дундаж температур цельсийн 0.4<sup>0</sup>. Агаарын чийгшлийн хэмжээ 54-74% жилийн дундаж 65% байна.

2.1.3 **Ус зүй:** Адуунчулууны ордын район нь зүүн урагш ба хойшоо аажмаар намссан сул дов толгодорхог тал бөгөөд хүрээлэн байгаа хөндийнүүдэд Баяннуур, Цайдам нуур, Шүүтийн тойром, зэрэг давст нуурууд байдаг. Эдгээр нууруудын усны түвшний үнэмлэхүй өндөр 713,0-738 м байна. Орд нь доворхог налуу гадаргуутай. Районы хэмжээнд усан сүлжээ сул хөгжсөн ба гол төлөв гадагшаа урсгалгүй хотгоруудад цутгадаг түр зуурын жижиг горхиуд байдаг. Ордоос урагш 8 км зайтай урсан өнгөрдөг Хэрлэн гол нь тухайн районы ганц байнгын урсгал ус юм.

2.1.4 **Ургамал:** Тус сумын нутаг ботаник газар зүйн мужлалтаар дээгүүр, Монголын хээрийн тойргийн Нялгын районд хамаарна. Уулын хээрт. Цахилдаг, алаг өвст, хиаг-хялганат, бужмаг, хонгорзул, улалж, бут бударгана, харгана, халгай, буурцагт өвсний төрөл зонхилно. Тал хээрт: Үетэн хялганат, хазаар өвс, хиаг-хялганат, шарилж, лууль, дэрс болон амт чанар, шимт сайтай үетэн, буурцагт, алаг өвсний төрлийн ургамал зонхилно. Мөн гол, булаг, нуур тойрмын хөвөөгөөр хиаг, хазаар өвс, салхин ерхөг, дэрс, харгана, адамсын агь, хэрс

зэрэг ургамал ургадаг ба сумын урд говирхог талаараа таана, мангир, хөмүүл, ерхөг, үетэн хялганат, алаг өвс, жижиг бутан үетэн, ботуульт ургамал зонхилон ургадаг байна.

**2.1.5 Агнуурын ан амьтан:** Үнэг, хярс, бор туулай, цагаан зээр зэрэг ан амьтан элбэг тааралдах ба сүүлийн жилүүдэд байгалийн хувьсан өөрчлөлт, хүний буруутай үйл ажиллагааны улмаас тарвага, цагаан зээр зэрэг агнуурын ан амьтад эрс ховордсон байна. Жигүүртэн шувуу: Энэ төрлийн шувуудаас Хэрлэн сумын нутаг дэвсгэрт бүх төрлийн начин шонхор, хээрийн болжмор зэрэг шувууд байдаг.

## **2.2 Хүн ам, эдийн засаг, зам харилцаа:**

**2.2.1** Хэрлэн сум нь 65000 хавтгай дөрвөлжин км нутагтай, Хэрлэн голын хоёр талд Матад, Булган, Баянтүмэн, Чойбалсан сумтай хиллэдэг. Засаг захиргааны үндсэн нэгж 11 багтай, 46000 хүн амтай, 12400 өрхтэй, 120000 толгой малтай. Үүнээс тэмээ 330, адуу 16000, үхэр 15600, хонь 54000, ямаа 34000 байна. Аж үйлдвэр, худалдаа үйлчилгээ, боловсрол соёл, эрүүл мэнд, хувийн хэвшлийн 600 гаруй аж ахуйн нэгж тус суманд үйл ажиллагаа явуулдаг. Чойбалсан хот нийслэлээс 656 км алслагдсан бөгөөд д.т.д 700м өндөрт оршдог.

## **2.3 Талбайн геологийн судалгааны түүх, геологийн тогтоц**

### **2.3.1 Геологийн судалгааны түүх**

Адуунчулууны орд газрын районд 1934 оноос эхлэн анхны дэс дараалсан геологийн судалгаа хийгдэж эхэлжээ.

1934 онд В.Н.Поповоор удирдуулсан ураны хайгуулын 1-р ангийнхны явуулсан ажлын үр дүнд Баян булагийн хүрэн нүүрсний ордын тухай анхны мэдээлэл бий болжээ.

1939 онд В.И.Жереховын удирдлагаар Дорнод аймагт 1:200000-ны масштабтай зураглалын ажил явуулж Баянбулаг, Хутаг, Цагааннуур, Жаргалантын хүрэн нүүрсний ордуудыг илрүүлсэн байна.

1951-1952 онуудад Баянбулагийн ордын үргэлжлэл талбайд К.Б.Столбововын удирдлагаар хийсэн ураны эрдэсжилт судлах ажлын үр дүнд Баянбулагийн ордоос зүүн урагш 16 км-ын зайд Адуунчулууны хүрэн нүүрсний орд газрыг илрүүлэн улмаар эрлийн ажил явуулан дээд талдаа 0.093 % -ийн



агуулгатай, 1100 гамма хүртэл цацраг идэвхижилтэй эрдэсжилт бүхий нүүрсний нилээд зузаан давхарга байгааг тогтоожээ.

1953 онд В.Д.Кирейчевийн удирдлагаар Чойбалсангийн хотгорт 1:200000-ны масштабтай зураглалын ажилтай хавсарган нефтийн эрлийн ажил хийсний үр дүнд Чойбалсангийн хотгорын тектоникийн тогтоцыг бататган судалсан.

1962 онд Адуунчулууны орд газарт В.А.Сороко, С.Ф. Дымченко нарын удирдлагаар хайгуулын ажлыг явуулж, хүрэн нүүрсний нөөцийг 29.2 сая тонноор тооцоолжээ.

1965 онд уг ордод В.А.Картавин, В.Н.Череповский нар Гидрогеологийн судалгаа явуулж нүүрстэй болон нүүрсний доорхи ус агуулсан давхаргуудын хооронд ямарч холбоо байхгүй, нүүрсний доорхи давхаргын ус даралттай болохыг тогтоожээ.

1981 онд Адуунчулууны орд газарт Я.Бямбадоржийн удирдлагаар гидрогеологийн судалгаа явуулж, нүүрст давхаргын доод талын даралттай ус агуулсан давхаргын усны зохих түвшингүүдийг судалснаар ямарч тохиолдолд нүүрсний давхаргад хагарал үүсэхгүй гэсэн дүгнэлт өгсөн байна.

1988 онд Л.Мөнхтоогогийн удирдлагаар тус ордод эрлийн ажлыг явуулснаар ордын геологийн хил заагийг бүрэн тогтоож, одоогийн ашиглалтын хилээс хойгуур, ордын геологийн тогтоцыг судлан нүүрсний чанар, нүүрсжилтийн байдал зэргийг судалсан.

### 2.3.2 Геологийн тогтоц

Ордыг 1954-1966 онуудад далд, 1969 оноос ил аргаар ашиглаж Дорнод аймгийн түлшний хэрэгцээг хангаж ирсэн. Тус ордын нүүрсний уналын өнцөг нь 5° буюу бараг хэвтээ, хөрсний зузаан харьцангуй бага, нүүрс болон хөрс зөөлөн, өвөлдөө 3 метр орчим хөлддөг, уст давхарга нь ашиглалтын явцад нөлөөлөл багатай зэрэг нь ашиглалтын талаасаа таатай нөхцөлтэй гэж тооцохоор байна.

Орд хэвтээ тогтоцтой тул ачаа тээврийн онцгой хүндрэл гарахгүй бөгөөд хөрсний доголудын доод үеүдийн хөрсийг дотоод овоолгод хурааж, хөрс тээвэрлэх зардал хэмнэх бололцоотой. Хөрс, нүүрсний бат бөхийн коэффициент  $f < 4$  (проф. Портодъякновын ангиллаар) байгаа нь дулааны улиралд өрөмдлөг тэсэлгээний ажил хийхгүйгээр шууд ухаж шидэх эсвэл

тээврийн хэрэгсэлд ачих боломжтой. Хүйтний улиралд уулын ажил явагдах хэсгийг хөлдөлтөөс хамгаалахаас гадна хөлдснийг гэсгээж сийрэгжүүлж дараагийн процессийг явуулах бололцоо байна. Мөн нилээд нягт хүнд шаварлаг үе хөрсний доголудад гарч ирэхэд бага хэмжээний тэсэлгээ хийж сийрэгжүүлэх ажиллагаа хэрэгжүүлж байгаа. Тэсэлгээгээр сийрэгжүүлэх хөрсний хэмжээ бага бөгөөд нийт хөрс хуулалтын 5-10%-ийг эзэлнэ.

### 3. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт

Адуунчулуун уурхайгаас нүүрс олборлох төслийн БОНБНУ-ээр төслийн гол болон болзошгүй нөлөөллийг дараах байдлаар тодорхойлсон байдаг

Хүснэгт №4 БОННУ-ээр тогтоосон төслийн гол ба болзошгүй нөлөөлөл

№	Байгаль орчны үзүүлэлт	шууд	шууд бус	өөрөө	богино хугацааны	урт хугацааны	буцаж нөлөөлөх	буцалтгүй	сул хүчтэй	дунд хүчтэй	хүчтэй
1. Байгалийн төрөл зүйлийн өөрчлөлт											
1	Газрын доорх урсацын өөрчлөлт		x			x		x	x		
2	Гадаргын усны урсацын өөрчлөлт			x							
3	Ургамлын бүтцийн өөрчлөлт	x			x			x		x	
4	Хөрсний элэгдэл, эвдрэл	x			x	x				x	
5	Геологийн тогтоцын өөрчлөлт	x			x					x	
6	Зэрлэг амьтдын орон зай		x	x	x			x		x	
7	Уур амьсгалын (бичил) өөрчлөлт		x						x		
2. Байгалийн нөөцийн ашиглалт											
8	Газрын гадаргын нөөц баялаг		x		x			x		x	
9	Бэлчээрийн талбай талхлагдахаас сэргийлэх	x				x				x	
10	Эрдэс түүхий эд, нөөц	x								x	
11	Эрчим хүчний нөөц										
3. Байгаль орчны чанарын өөрчлөлт											
12	Ундны усны чанар, хэмжээ		x		x			x		x	
13	Газрын доорх усны чанарын өөрчлөлт		x		x				x		
14	Урсгал усны хэрэглээ	x			x				x		
15	Агаарын бохирдол	x				x				x	
16	Хөрсний эвдрэл бохирдол	x			x					x	
17	Хорт бодис усаар дамжин хүн, амьтанд нөлөөлөх		x		x				x		



18	Дуу, чимээ шуугианы нөлөөлөл	x				x							x	
4. Байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палентологийн олдвор														
19	Байгалийн үзэсгэлэнт төрх өөрчлөгдөх	x				x								x
20	Ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх	x				x							x	
21	Тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх													
22	Түүх соёлын дурсгалт зүйлд нөлөөлөх													
23	Археологи, палентологийн олдворт нөлөөлөх													
5. Нийгэмд үзүүлэх нөлөөлөл														
24	Дэд бүтцийн хөгжилд нөлөөлөх	x				x							x	
25	Үйлчилгээний салбарын үйл ажиллагаанд нөлөөлөх	x				x							x	
26	Хүн амын орлого нэмэгдэж өөрчлөгдөх		x			x		x						
27	Хүн амын тоо нэмэгдэх		x			x								
6. Эдийн засаг, байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл														
28	Хувийн өмчийн болон татварын орлого өөрчлөгдөх	x				x							x	
29	Орон нутгийн орлого нэмэгдэх	x				x		x	x					
30	Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох		x			x		x	x					
31	Ажлын байр нэмэгдэх	x				x							x	
32	Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх	x				x							x	
33	Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх		x		x							x		
34	Газар тариалан, мал аж ахуйд нөлөөлөх		x			x						x		
7. Бусад нөлөөлөл														
35	Шороон зам харилцаа, хогийн цэгийн ажлын машин механизмын хөдөлгөөн шилжилтээс үүдэх хөрсний эвдрэл	x				x								x
36	Ахуйн хог, хаягдал, хогийн цэгийн ариутгал муугаас эвгүй үнэр гарах, шавьж үржих	x												x
Дүн		19	12	2	13	16	0	8	9	17	3			

### 3.1 Байгалийн төрөл зүйлийн өөрчлөлт:

Адуунчулуун нүүрсний ордыг ашиглах талаар байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг болох геологийн тогтоц, хөрс, ургамалд шууд нөлөөлж эдгээр нь богино хугацаанд, хүчтэй болон дунд хүчтэй эрчмээр нөлөөлнө. Уг төслийг байгуулах үед тээврийн хэрэгслийн зам, машин техникийн шатахуун тослох материалыг асгах, хог хаягдал ил задгай хаях зэрэг нь хөрсийг бохирдуулах нөлөө гарч болзошгүй. Мөн салхи ихтэй улиралд ордоос чулуу,



материал ашиглах, бэлдэх үе шатуудад шороо тоос босч агаар орчныг бохирдуулах нөлөөлөл гарч болно. Хөрс элэгдэл эвдрэлд өртөн дагтаршиж ургамлан бүрхэвчийн бүтэц өөрчлөгдөх, малын бэлчээр нутаг хумигдах зэргээр сөрөг нөлөөлөл үзүүлнэ. Гэвч эдгээр нь төслийн барилга байгууламж баригдах хугацаанд үзүүлэх сөрөг нөлөө бөгөөд авто зам баригдсаны дараа бэлчээр талхлагдахаас сэргийлэгдэх зэргээр байгаль экосистемийн урт хугацааны эерэг нөлөөлөл бий болгоно.

**3.1.1 Агаарын чанар:** Адуунчулуун нүүрсний ордыг ашиглах үед материал тээвэрлэх, уурхайн дотоод тээвэрлэлт, хөрс хуулах үед тоос, дуу чимээ гарч орчны агаарын чанарт сөрөг нөлөө үзүүлж байна. Үүнийг зам дагуу услаж тоосжилтыг бууруулах арга хэмжээ авч ажиллана.

**3.1.2 Хөрс, ургамлан бүрхэвчийн элэгдэл, эвдрэл:** Адуунчулуун нүүрсний ордыг ашиглах байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг болох геологийн тогтоц, хөрс, ургамалд шууд нөлөөлж эдгээр нь богино хугацаанд, хүчтэй болон дунд хүчтэй эрчмээр нөлөөлнө. Төслийн үед хөрс, ургамлан нөмрөг шууд өртөнө. Мөн зам байгуулах болон тээврийн хэрэгслийн зам, машин техникийн шатахуун тослох материалыг асгах, хог хаягдал ил задгай хаях зэрэг нь хөрсийг бохирдуулах нөлөө гарч болзошгүй.

### 3.1.3 Уурхайн ус хангамж, усны хэрэглээ

Уурхайн гүний шүүрлийн ус нь “Монголын Алт МАК” ХХК-ийн 14892 ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайд байрлах “Адуунчулуун” ХК-ийн зумпфэнд цугларч ЭЦВ8-25-125 насосоор хоногт дундажаар 14 цаг буюу 345,0 м3/хоног ус татан зайлуулж Хэрлэн сумын 8 дугаар багийн нутагт байрлах Баяннуурт шахагдаж байдаг. Шүүрлийн ус шавхан зайлуулахдаа зумпфэнд хуримтлагдсан усаа насосоор шахдаг. Ус шавхалт нь тоолууртай, насосны хоногт ажилласан цаг зумфын насосчдын ажлын тэмдэглэл, насосны хүчин чадал, улирлын байдлаас хамааран доорхи байдлаар ажилладаг. Үүнд:

1. Намрын сүүл болон өвлийн -(11,12,1,2,3,4-саруудад) 10цаг/хоногт
  2. Зуны - (6,7,8-саруудад) 20цаг/хоногт
  3. Хаврын сүүл болон намрын дунд- (5,9,10-саруудад) 16цаг/хоногт
- 2019 онд ЭЦВ8-25-125 насосоор ажилласан ус шавхалтын тооцоог дээрхи хугацаанд хийвэл:

1. 6 сар\*30 хоног\*10 цаг =1800 цаг



2. 3 сар\*30 хоног\*20 цаг =1800 цаг
3. 3 сар\*30 хоног\*16 цаг =1440 цаг

Насос жилд 5040 цаг\*25м3/цаг = 126 000 м3/жил ус шавхан зайлуулна.

2023 онд Хүн амын унд, ахуйн зориулалтаар ашиглах усны хэмжээ 5000 м3 байхаар төлөвлөсөн бөгөөд өдөр тутам аймгийн төвөөс баллонтой цэвэр ус зөөвөрлөнө.

Уурхайн дотоод болон нүүрс тээврийн шороон зам усалгаанд 3000 м3 ус хэрэглэхээр төлөвлөсөн. Тухайн усыг “Адуунчулуун” ХК-ийн ус шүүрүүлэх зумфпнээс 20 м3-ийн багтаамжтай машинаар усаа авч тоосжилт дарах, нүүрсний халалт уугилттай хэсгийг усална. .

2023 онд нийт 11,000 м3 ус хэрэглэхээр төлөвлөсөн бөгөөд үүний зардал болон төлбөрт 1,150,000 төгрөгийг төсөвлөсөн. Энэ усны хэрэгцээ нь зуны улиралд нүүрсэнд халалт, уугилт болон их хэмжээний гал гарсан тохиолдолд нэмэгдэх боломжтой.

Нүүрс агуулсан хурдас нь даралтгүй устай бөгөөд усны түвшин 11.75-54.5 м-ийн гүнд оршино. Газар доорх усны чиглэл ордыг баруун хойд талаас зүүн урагш чиглэлтэй.

Нүүрсний ус агуулсан давхаргад туршилтын шавхалт явуулж, уурхайд орж ирэх усны тооцоо, гидрогеологийн үндсэн үзүүлэлтүүдийг тооцсон байна.

Хүснэгт №5. Ил уурхайд орж ирэх усны хэмжээ

Үзүүлэлт	Хэмжих нэгж	Хэмжээ
Ил уурхайн ордын хэмжээнд орж ирж болох гүний усны дундаж хэмжээ	м3/цаг	203.8
Хур тунадасаар ил уурхайд хамгийн их огцом орж ирэх усны хэмжээ	м3/цаг	1006.5

Хүснэгт №6. Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх

№	Байгаль орчны бүрэлдэхүүн	Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл	Нөлөөллийн ангилал, хамрах хүрээ
1	Хөрс	Хөрс хуулах	2.6 га талбай ахилтанд өртөх ба шимт хөрсийг тусад нь хуулна
		Овоолго байгуулах	Хөрс хуулалтаас гарах 750 мян.м3 уулын цулыг дотоод хураана

		Тээвэрлэлт	Уурхайн дотоод 1 км замаар тээвэрлэнэ. ДЦС хүртэл хатуу хучилттай замтай болно
		Үерийн хамгаалалтын далан суваг сэргээх	Хуучин далангуудыг сэргээх тул шинээр газар өртөхгүй
		Хөрсний бохирдол үүсэх	Хог хаягдлыг зориулалтын цэгт хаяхгүй байх, техникийн засвар үйлчилгээг замбараагүй хийснээс хөрс бохирдож болзошгүй
2	Агаар	Тоосжилт үүсэх	Тээвэрлэлт, хуурайшилт, салхи ихтэй үед тоосжилт үүснэ
		Нүүрсний шаталт	Болзошгүй нөлөөлөл бөгөөд богино хугацаанд түр бохирдуулна
		Хогийн цэгийн ариутгал	Хог хаягдлыг тогтмол зайлуулахгүй, ариутгал хийхгүй тохиолдолд эвгүй үнэр гарах, ялаа шавьж үржиж халдварт өвчин гарч болзошгүй
3	Ус	Гадаргын ус	Гадаргын усанд нөлөөлөл үзүүлэхгүй
		Газрын доорх ус	Уурхайн гүний усыг шавхана
4	Ургамал	Ургамлын нөмрөг устгах	2.6 га талбайн ургамлан нөмрөг хөрс хуулалтанд өртөнө
		Ургамлан нөмрөг доройтох	Зохион байгуулалтаас шалтгаалж бэлчээр талхлагдаж, тоосонд дарагдаж болзошгүй
5	Амьтан	Шувууд болон зэрлэг амьтад	Уурхайн ойр орчимд шувуудаас өөр зэрлэг амьтан ховор тул сөрөг нөлөөлөл бага байна

#### 4. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний

##### гол зорилт, хамрах хүрээ

Төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний үндсэн зорилго нь төслийг хэрэгжүүлэх явцад үүсэх бүхий л сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг төслийн хэрэгжилтийн хүрээнд авч үзэн, холбогдох зардлыг



бодитоор төлөвлөх, улмаар энэхүү төлөвлөгөөг төсөл хэрэгжүүлэгч дагаж мөрдсөнөөр байгаль орчин, нийгмийн хамгааллын үүргээ хангах нөхцлийг бүрдүүлэх юм.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний үндсэн зорилгыг хангахын тулд төсөл хэрэгжүүлэгчийн санхүүгийн чадавхын хүрээнд нийгмийн хариуцлагыг өндөржүүлэхэд чиглэсэн дараах зорилтыг хангана. Үүнд:

- БОМТ-нд тусгасан ажлын дараалал, түүнийг хийж гүйцэтгэснээр хүрэх үр дүнг нөхөн сэргээлтэнд тавих шаардлагын хэмжээнд хүргэх
- БОМТ-ний хэрэгжилтийг төсөл хэрэгжүүлэгч өөрөө болон орон нутгийн оршин суугчдын зүгээс хэрхэн хянаж, харилцан хамаарал бүхий бодит үр дүнд хүрэх
- БОМТ-г зохих ёсоор хэрэгжүүлснээр төсөл хэрэгжүүлэгчийг хөндлөнгийн хяналт, шалгалтад бэлэн байлгах зэрэг нөхцлүүдийг тодорхойлох

**Хамрах хүрээ:**

Адуунчулуун уурхайн MV-1364А ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайд явагдаж байгаа үндсэн олборлолтын үйл ажиллагааны БОННУ-г холбогдох хууль, журмын дагуу БОАЖЯ-аар батлуулсан. Уурхайн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг нэгтгэсэн болно.

**5. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ**

**5.1 Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө**

Хүрээлэн буй орчны агаарын чанар, гадаргын ба газрын доорх ус, хөрсөн бүрхэвч, газрын хэвлий, ургамлан нөмрөг, амьтны аймагт нөлөөлж буй аливаа сөрөг нөлөөллийг бууруулахын тулд дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ.

Хүснэгт №7 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмж их нэгж	Нэгжийн зардал	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9

1	Агаарын чанар	Уурхайгаас "ДБЭХС" ТӨХК хүртэл 7.6 км авто замын хатуу хучилтгүй 2 км шороон замыг тогтмол услах	Зам дагуух ургамлан нөмрөг	мг/м3	40,000	4	160,000	Улиралд 1 удаа жилд 4 удаа агаарын чанарын шинжилгээ хийлгэнэ.	MNS4048:1988
		Нүүрс тээвэрлэх явцад хүнд даацын автомашинаас нүүрс унагахгүйн тулд автомашины хучлагыг жил бүр шинэчилнэ	Нүүрс тээврийн зам дагуу	Ком	124,000	8	992,000	Жилд 1 удаа	"Агаарын тухай" хууль; MNS 4585:2007 "Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага" -
2	Гадаргын ба газрын доорхи усны нөөц	Уурхайн шүүрлийн усыг бохирдуулахгүй байх, зохистой ашиглах	Газрын гүний усыг бохирдуулах	мг/л	74,500	4	298,000	Улиралд 1 удаа жилд 4 удаа шүүрлийн усанд шинжилгээ хийлгэнэ.	MNS4943:2011
3	Хөрсөн бүрхэвч	Уулын ажилд өртөх шимт хөрсийг хадгалах	Уулын ажлын үйл ажиллагааны хүрээнд хуулсан шимт хөрсний ойр орчмын ургамлан нөмрөг	мк/гр	56,900	1	56,900	Жилд 1 удаа хүнд агро-химийн шинжилгээ хийлгэнэ.	MNS5916:2008
4	Газрын хэвлий	Химийн болон нефтийн бүтээгдэхүүнээр газрын хэвлий бохирдуулахаас сэргийлэх	Газрын хэвлий ба түүний орчин	мк/гр	80,000	1	80,000	Жилд 1 удаа хүнд элементийн шинжилгээ хийлгэнэ.	MNS5916:2008
5	Ургамлан нөмрөг	Олон салаа зам гаргахгүй тогтсон маршрутаар явах,	Ашиглалтын талбай болон болон "ДБЭХС" ТӨХК-рүү нүүрс тээвэрлэх замын дагуух	мк/гр	56,900	1	56,900	Жилд 1 удаа ургамлан нөмрөгт шинжилгээ хийлгэнэ.	MNS5917:2008
6	Амьтны аймаг	Уулын ажлыг ан амьтдад аюулгүй байхаар явуулах	Тусгай зөвшөөрөлтэй талбайн хүрээнд	-	-	-	-	-	-
Нийт							1,271,800		

Уурхайн олборлолтонд өртөх болон хөрсний чулуулгийн гадаад овоолгод дарагдах бүх талбайн үршил шимт хөрсийг хөрсний үндсэн төрөл, хэв шинжээс



нь хамааруулан урьдчилан 0.3-0.5 м-ийн зузаантайгаар хуулж тусгайлан хадгалах бөгөөд ордыг ашиглаж дууссаны дараа нөхөн сэргээлтэнд ашиглана.

Шимт хөрсний овоолго хадгалалтын явцад ялзмагийн агууламж 2%-иас багагүй, уусмалын орчин (Ph) 6.5-7.8 байх нөхцөлийг бүрдүүлэн овоолгыг 37<sup>0</sup> налуутай, 5-10 метр өндөртэйгээр, үер борооны ус, салхины эвдрэл, элэгдэлд орохооргүй байхаар байрлуулан хадгална гэж тооцсон. Шимт хөрсний овоолгын эзэлхүүн 92.7 мян.м3 байна.

Уурхайн гүний усны хяналт шинжилгээний худгуудын мэдээллийг мониторинг хийхэд ашиглана. Шаардлагатай тохиолдолд уурхайн ус шүүрүүлэх зумпийн усанд хяналт шинжилгээ хийх боломжтой.

Төслөөр 9,785.95 мян.м3 хөрс хуулж, 4,947.17 мян.тн нүүрс олборлож 28.3 га талбайг хамарсан ашиглалт явуулна. Ил уурхайгаас хуулах хөрсийг ашиглагдсан орон зайд дүүргэлт хийх, уурхайн хажууг хэлбэршүүлэн овоолох замаар дотоод овоолго үүсгэнэ. Ашиглалт явагдаж дууссаны дараа дотоод овоолгын талбайг хэвгийжүүлж техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийнэ.

**Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах:** Машин техникээс ялгарах хорт хийн агууламжийг тогтмол хянаж, утаа ихээр гаргаж буй машин механизмыг үйл ажиллагаанд ашиглахгүй байх засвар үйлчилгээ хийх

- Уурхайн авто замуудыг дулааны улиралд болон тоос ихээр босох үед усалгаа хийж чийгшүүлэх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэх, 10 м/с-ээс дээш салхитай үед газар шорооны ажил хийхгүй байх
- Нүүрс түр хадгалах нүүрсний агуулахын талбайн захаар салхины торон өндөр хаалт хийж, нүүрсний тоос хийсэж орчныг бохирдуулахаас хамгаалах
- Уурхайн ажлын талбай, дотоод шороон замыг үйл ажиллагааны туршид усаар чийглэж байх, зарцуулсан усны бүртгэл хөтлөх
- Замын тэмдэг тэмдэглэгээ хийх, уурхайн дотоод замд тээврийн хэрэгслийн хурдыг хязгаарлах
- Шаардлагагүй олон салаа зам гаргахгүй байх, тогтсон маршрутаар тээврийн хэрэгслийг зорчуулж байх

- Зөвшөөрөгдөх хэмжээнээс давсан хий, бохирдуулах бодис ялгаруулж буй машин механизм, техник төхөөрөмж хэрэглэхийг хориглох

**Газрын гадарга болон газрын хэвлийд үзүүлэх нөлөөллийг бууруулах:**

- Газар шорооны ажлын үед үржил шимт хөрсний хуулалт, хадгалалт, овоолгыг стандартын дагуу хийх
- Хөрсний овоолгыг салхинд хийсэж, тоос шороо дэгдэхээс урьдчилан сэргийлж, тэгшилж, нягтруулах, хэлбэржүүлэх
- Уурхайн карьер, өөр бусад нүх, суваг, далан руу хүн, мал амьтан унаж, бэртэх аюулаас урьдчилан сэргийлж, хашлага, хаалт хийж тэмдэгжүүлэх
- Барилга байгууламж барих болон ямар нэгэн дэд бүтцийг байрлуулахаас өмнө өнгөн хөрсийг хуулж, овоолго үүсгэн хадгалах

**Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах:**

- Шимт хөрсний овоолгыг салхинд хийсэх, усанд автах, хужиртах, хатуу биет, чулуу, барилгын болон бусад хаягдалд дарагдаж бохирдохоос хамгаалах, урьдчилан сэргийлэх
- Хоёр жилээс дээш хугацаагаар хадгалах шимт хөрсний овоолгын дээд гадаргуу, хажууг хэлбэршүүлж, олон наст өвслөг ургамал тарих
- Машин техникийн шатахуун, тос тосолгоо, гидравлик шингэний асгаралт, шүүрэлтийн хяналтыг тогтмол хийх
- Машин техникийн засвар үйлчилгээний талбай, ШТС болон бусад шаардлагатай талбайнуудыг цемент, хөрсөнд бохирдол нэвчүүлэхгүй байх бусад материалыг ашиглах

**Газрын доорх усанд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах:**

- Уурхайн үйл ажиллагааны явцад тоосжилт дарахад ахуйн хаягдал усыг цэвэршүүлж чийгшүүлэлтэд ашиглах
- Шүүрлийн усыг зайлуулах насос болон тоног төхөөрөмжид усны тоолуур суурилуулах
- Засварын газар болон тоног төхөөрөмжийн сольсон шатах тослох материал хадгалах талбай зэргийг үл нэвчүүлэх геомембраныг ашиглах тохижуулах



- Хур тунадасны ус ялангуяа хүчтэй аадар борооны үед шатах тослох материал болон ахуйн хаягдал хогийг урсган ойр орчмын усан орчин, сайрын голдиролд орж бохирдуулах нөхцөл үүсэхээс урьдчилан сэргийлэх
- Шатах тослох материал, бусад хортой, аюултай бодис алдагдах, асгарах үед авах яаралтай арга хэмжээг урьдчилан тодорхойлж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах
- Ахуйн бохирыг зайлуулах байгаль орчин, усны чанарт халгүй орчин үеийн системийг төлөвлөж, хэрэглэх
- Үйлдвэрлэл явуулах талбайг аль болох бага, цомхон байхаар төлөвлөж, байгалийн ургамал, хөрсөн бүрхэвчийн унаган төрхийг хангах тал дээр онцгой анхаарах

**Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах:**

- Хууль бус агнуур хийх, амьтны үр зулзага, үүр өндгийг сүйтгэх зэрэг зөрчлийг гаргуулахгүй байх
- Уулын малталт, овоолгыг зэрлэг амьтдад аюулгүй байхаар байрлуулах
- Төслийн үйл явцад гарах хатуу болон шингэн хог хаягдлыг зориулалтын цэгт хаях, халдваргүйжүүлэх, булшлах зэрэг арга хэмжээг авах
- Ан амьтны тухай хууль, тогтоомжийг чандлан биелүүлэх

**Хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ:**

- Үйлдвэрлэлийн ажлын онцлог, ажиллагсдын онцлогоос шалтгаалахгүйгээр тэднийг аюулгүй ажиллагааны арга барилд сургах зааварчлах ажлыг тодорхой дэс дараалалтайгаар гүйцэтгэх
- Ажилчдад аюулгүй ажиллагааны зааварчилгааг тогтоосон хугацаанд өгөх, хөдөлмөрийн аюулгүй ажиллагаанд сургаж дадлагажуулах
- Гадны байгууллагаас ажиллах болвол аюулгүй ажиллагааны зааварчилгаанд бүх ажилчдын нэгэн адил хамруулна. Ажилд шинээр орсон, өөр ажилд шилжин ажиллаж байгаа хуучин ажилчид аюулгүй ажиллагааны зааварчилгаа авсны дараа уг ажилд орно.
- Тоног төхөөрөмжинд хаалт, хамгаалалтыг зориулалтын дагуу хийх ажлыг зохион байгуулах
- Ажиллагсдад эрүүл ахуй, хөдөлмөрийн нөхцөл, эрүүл мэндийн чиглэлээр мэдлэг олгох сургалтыг зохион байгуулах

## 6. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Хүснэгт №8 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	
1	Техникийн нөхөн сэргээлт	2 га талбайд нөхөн сэргээлт хийнэ	га	2	9,030,600	18,061,200	2022 оны 4-10 сар	Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас эвдэрсэн газрын нөхөн сэргээлт MNS5917:2008
2	Биологийн нөхөн сэргээлт	2 га талбайд нөхөн сэргээлт хийнэ	га	2	4,920,000	9,840,000	2022 оны 4-10 сар	Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт MNS5914:2008
3	Татан буулгах, хаалтад бэлтгэх	-	-	-	-	-	-	-
	Нийт			4	13,950,600	27,901,200		

### 6.1 Техникийн нөхөн сэргээлт

Уурхайн олборлолтонд өртөх болон хөрсний чулуулгийн гадаад овоолгод дарагдах бүх талбайн үржил шимт хөрсийг хөрсний үндсэн төрөл хэв шинжээс нь хамааруулан урьдчилан 0.3-0.5 метрийн зузаантайгаар хуулж тусгайлан хадгалах бөгөөд ордыг ашиглаж дууссаны дараа нөхөн сэргээлтэнд ашиглана.

Шимт хөрсний овоолго хадгалалтын явцад ялзмагийн агууламж 2%-иас багагүй уусмалын орчин (Ph) 6.5-7.8 байх нөхцлийг бүрдүүлэн овоолгыг 37 градусын налуутай, 5-10 метр өндөртэйгээр үер борооны ус салхины эвдрэл, элэгдэлд орохооргүй байхаар байрлуулан хадгална гэж тооцсон.

Шимт хөрсний овоолгын эзэлхүүн 92.7 мян.м<sup>3</sup> байна.

Төслөөр 9,785.95 мян.м<sup>3</sup> хөрс хуулж 4,947.17 мян.т нүүрс олборлож 28.3 га талбайг хамарсан ашиглалт явуулна. Ил уурхайгаас хуулах хөрсийг ашиглагдсан орон зайд дүүргэлт хийх уурхайн хажууг хэлбэршүүлэн овоолох замаар дотоод овоолго үүсгэнэ. Ашиглалт явагдаж дууссаны дараа дотоод овоолгын талбайг хэвгийжүүлж, техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийнэ



2023 онд тусгай зөвшөөрөлтэй талбайн баруун урд хэсэгт 2 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийнэ. Мөн дотоод овоолгын хажуугийн налууг зохих хэмжээнд оруулж дахин хэлбэржүүлэлтийн ажил хийнэ. 2023 онд 2,3 га талбай ашиглалтанд өртөх бөгөөд уурхайн ахилтад шинээр өртөх талбайн 8190 м3 шимт хөрс хуулж тусад нь овоолж хадгалах ба уурхайн баруун урд байрлах биологийн нөхөн сэргээлт хийх талбайд ашиглана. Хөрс хуулалтаас гарах 750.000 м3 уулын цулыг зөөж дотоод овоолго байгуулан уурхайн ашиглагдсан хоосон орон зайг дүүргэнэ. Энэ нөхөн сэргээлтийн ажлыг уурхайн ашиглалттай зэрэгцүүлэн явуулах, тээвэрлэлтийн зайг багасгаж зардал хэмнэх ач холбогдолтой.

Техникийн нөхөн сэргээлтийг дараах стандартуудын дагуу хийнэ.

- Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Нэр томъёо, тодорхойлолт MNS:5914:2008
- Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын ангилал MNS:5915:2008
- Газар шорооны ажлын үед шимт хөрс хуулалт, хадгалалт MNS:5916:2008

Хөрс хуулалт болон техникийн нөхөн сэргээлтийн ажилд гидро экскаватор, утгуурт ачигч, автосамосвал, бульдозер хослон ажиллана. Техникийн нөхөн сэргээлтийн ажлыг өөрийн техник, ажиллах хүчээр гүйцэтгэнэ.

Хүснэгт №9 Нөхөн сэргээлт хийх ажилд ашиглах тоног төхөөрөмж

№	техникийн нэрс		тоо ширхэг	хэмж их нэгж	хэмжээ	ээлжийн бүтээмж м3	түлш зарцуулалт мото/цаг
	марк	төрөл					
1	Экскаватор	XCMG	1	м3	5	4000	60
2	Утгуурт ачигч	Foton lovol	1	м3	3		20
3	Автосамосвал	XCMG	4	м3	25	4000	120
4	Бульдозер	XCMG	1	м3	4.5		30

Олборлолт нөхөн сэргээлтийн ажлыг зэрэг явуулах ба 2022 онд хийсэн дотоод овоолгыг үргэлжлүүлэн хийнэ. Техникийн нөхөн сэргээлтийн ажилд ашиглалтанд өртөх 2,6 га талбайн шимт хөрс хуулах, 2 га талбайг хэлбэршүүлэх, 2 га талбайд биологийн нөхөн сэргээлт хийж шимт хөрсөөр хучих зэрэг ажлууд орно.

Нөхөн сэргээлт хийхээр төлөвлөсөн газрын байршлын зураг, солбицлыг харуулсан зургийг хавсаргав.

2.6 га талбайн шимт хөрсийг хуулах, ачих, тээвэрлэх ажлын зардал:

Нийт хуулах шимт хөрсний хэмжээ:

$$V_{\text{шх}} = S_{\text{шх}} * 10^4 * h_{\text{шх}} * K_c = 2.6 \text{га} * 10000 \text{м}^2 * 0,3 \text{м} * 1,05 = 8190 \text{м}^3$$

$V_{\text{шх}}$ - нийт хуулах шимт хөрсний эзэлхүүн м<sup>3</sup>

$S_{\text{шх}}$ - шимт хөрс хуулах талбай 2,6 га

$h_{\text{шх}}$ - шимт хөрс хуулах үеийн зузаан 0,3 м

$K_c$ - ухаж ачих тээвэрлэх үеийн шимт хөрсний сийрэгжилтийн коэффициент 1,05

Хүснэгт №10 Бульдозероор 2,0 га талбайн шимт хөрс хуулах ажлын зардал

№	Зардлын нэр	Томъёо	Тайлбар
1	Нийт ажиллах хугацаа	$T=64$	T- тухайн ажлыг гүйцэтгэх хугацаа, цаг 8 хоног, өдөрт 8 цаг, нийт 64 цаг
2	Түлш, ШТМ-ын зардал	$C_{\text{дт}} = T * T_{3\text{ц}} * 1.15 * P_{\text{дт}} = 64 * 30 * 1.15 * 2 = 3312$	$C_{\text{дт}}$ - түлш, тосолгооны материалын хэрэгцээ, мян.төг $T_{3\text{ц}}$ - цагт зарцуулах түлшний норм 30л, 1.15- тосолгооны материалыг түлшний зарлын 15-иар тооцов, $P_{\text{дт}}$ - 1 литр д/түлшний үнэ 4.0 мян.төг
3	Сэлбэг	$C_{\text{сэ}} = X_{\text{Обульд}} * k * t / T_k = 100900 * 0.05 * 64 / 2060 = 165.7$	$C_{\text{сэ}}$ - сэлбэгийн зардал мян.төг $X_{\text{Обульд}}$ - бульдозерийн анхны үнэ k- сэлбэг тооцох анхны үнэ 5%
4	Цалингийн зардал	$C_{\text{ц}} = T * C_{\text{ц}} = 64 * 5.68 = 363.52$	$C_{\text{ц}}$ - цалингийн нийт зардал, мян.төг $C_{\text{ц}}$ - машинист, жолоочийн цагийн тарифт цалин 5.68 мян.төг
5	НДШ	$C_{\text{ндш}} = C_{\text{ц}} * 0.13 = 363.52 * 0.135 = 49.07$	$C_{\text{ндш}}$ - цалингийн сангийн 13.5%-иар бодно
6	Элэгдэл, хорогдлын зардал	$C_{\text{эхш}} = X_{\text{Отех}} * H_{\text{э}} * t / T_k = 100900 * 0.1 * 64 / 2060 = 313.47$	$C_{\text{эхш}}$ - элэгдэл хорогдлын шимтгэл мян.төг $H_{\text{э}}$ - элэгдэл хорогдлын шимтгэлийн норм, 10% $T_k$ - уурхай ажилд ажиллах нийт хугацаа, 2060 цаг T- хөрсний үеийг хуулах, түрэх хугацаа
Нийт зардал мян.төг		$C_{\text{нийт}} = C_{\text{дт}} + C_{\text{сэ}} + C_{\text{ц}} + C_{\text{ндш}} + C_{\text{эхш}} = 3312 + 165.7 + 363.52 + 49.07 + 313.47 = 4203.76$	



1 м3 шимт хөрс хуулах өөрийн өртөг	$a = \text{Снийт}/V = 4203.76/8190 = 0.513$	а- тухайн техникийн нэгж ажлыг гүйцэтгэх өөрийн өртөг мян.төг/м3
------------------------------------	---	--

Хүснэгт №11 Утгуурт ачигчаар 2,0 га талбайн шимт хөрс ачих ажлын зардал

№	Зардлын нэр	Томъёо	Тайлбар
1	Цагийн бүтээл	$Q=268.1$	Ээлжинд 2144.8 м3, цагт 268.1 м3 ажил хийнэ
2	Нийт ажиллах хугацаа	$T=48$	Т- тухайн ажлыг гүйцэтгэх хугацаа, цаг 6 хоног, өдөрт 8 цаг, нийт 48 цаг
3	Түлш, ШТМ-ын зардал	$C_{дт} = T * T_{3ц} * 1.15 * P_{дт} = 48 * 20 * 1.15 * 2 = 2208$	С <sub>дт</sub> - түлш, тосолгооны материалын хэрэгцээ, мян.төг Т <sub>3ц</sub> - цагт зарцуулах түлшний норм 20л, 1.15- тосолгооны материалыг түлшний зарлын 15-иар тооцов, P <sub>дт</sub> - 1 литр д/түлшний үнэ 4.0 мян.төг
4	Сэлбэг	$C_{сэ} = X_{Оковш} * K * t / T_k = 128000 * 0.05 * 48 / 2060 = 149.1$	С <sub>сэ</sub> - сэлбэгийн зардал мян.төг X <sub>Обульд</sub> - бульдозерийн анхны үнэ к- сэлбэг тооцох анхны үнэ 5%
5	Цалингийн зардал	$C_{ц} = T * Ц_{ц} = 48 * 8.52 = 408.96$	С <sub>ц</sub> - цалингийн нийт зардал, мян.төг Ц <sub>ц</sub> - машинист, жолоочийн цагийн тарифт цалин 8.52 мян.төг
6	НДШ	$C_{ндш} = C_{ц} * 0.135 = 408.9 * 0.135 = 55.2$	С <sub>ндш</sub> - цалингийн сангийн 13%-иар бодно
7	Элэгдэл, хорогдлын зардал	$C_{эхш} = X_{Отех} * H_{э} * t / T_k = 128000 * 0.1 * 48 / 2060 = 298.25$	С <sub>эхш</sub> - элэгдэл хорогдлын шимтгэл мян.төг H <sub>э</sub> - элэгдэл хорогдлын шимтгэлийн норм, 10% Т <sub>к</sub> - уурхай ажилд ажиллах нийт хугацаа, 2060 цаг Т- хөрсний үеийг хуулах, түрэх хугацаа
Нийт зардал мян.төг		$C_{нийт} = C_{дт} + C_{сэ} + C_{ц} + C_{ндш} + C_{эхш} = 2208 + 149.1 + 408.96 + 55.2 + 298.25 = 3119.51$	
1 м3 шимт хөрс хуулах өөрийн өртөг	$a = \text{Снийт}/V = 3119.51/8190 = 0.38$	а- тухайн техникийн нэгж ажлыг гүйцэтгэх өөрийн өртөг мян.төг/м3	

Хүснэгт №12 Автосамосвалаар 2,0 га талбайн шимт хөрсийг тээвэрлэх ажлын зардал

№	Зардлын нэр	Томъёо	Тайлбар
---	-------------	--------	---------

1	Тээвэрлэх рейсийн тоо	$n=Q/q_a=8190/25=327.6$	ХСМГ-NXG576 дампы ний багтаамж 25 м3
2	Түлш, ШТМ-ын зардал	$C_{дт}=n*2*L*T_{3100}/100*1.15*P_{дт}=327.6*2*1*20/100*1.15*2=301.39$	$C_{дт}$ - түлш, тосолгооны материалын хэрэгцээ, мян.төг $T_{3ц}$ - цагт зарцуулах түлшний норм 20л, 1.15- тосолгооны материалыг түлшний зардлыг 15-иар тооцов, $P_{дт}$ - 1 литр д/түлшний үнэ 4.0 мян.төг
3	Сэлбэг	$C_{сэ}=XO_{авто}*k*t/T_k=148000*0.05*48/2060=172.43$	$C_{сэ}$ - сэлбэгийн зардал мян.төг $XO_{авто}$ - машины анхны үнэ $k$ - сэлбэг тооцох анхны үнэ 5%
4	Цалингийн зардал	$C_{ц}=T*Ц_{ц}=48*5.68=272.64$	$C_{ц}$ - цалингийн нийт зардал, мян.төг $Ц_{ц}$ - машинист, жолоочийн цагийн тарифт цалин 5.68 мян.төг
5	НДШ	$C_{ндш}=C_{ц}*0.135=272.64*0.135=36.8$	$C_{ндш}$ - цалингийн сангийн 13.5%-иар бодно
6	Элэгдэл, хорогдлын зардал	$C_{эхш}=XO_{авто}*H_э*t/T_k=148000*0.1*48/2060=344.85$	$C_{эхш}$ - элэгдэл хорогдлын шимтгэл мян.төг $H_э$ - элэгдэл хорогдлын шимтгэлийн норм, 10% $T_k$ - уурхай ажилд ажиллах нийт хугацаа, 2060 цаг $T$ - хөрсний үеийг хуулах, түрэх хугацаа
Нийт зардал мян.төг		$C_{нийт}=C_{дт}+C_{сэ}+C_{ц}+C_{ндш}+C_{эхш}=301.39+172.43+272.64+36.8+344.85=1128.11$	
1 м3 шимт хөрс хуулах өөрийн өртөг		$a=C_{нийт}/V=1128.11/8190=0.138$	$a$ - тухайн техникийн нэгж ажлыг гүйцэтгэх өөрийн өртөг мян.төг/м3

Хүснэгт №13 Бульдозероор 2.0 га талбайг хэлбэршүүлэх ажлын зардал

№	Зардлын нэр	Томъёо	Тайлбар
	Тэгшлэх ажлын хэмжээ эзэлхүүн м3	$V_{пл1}=S_{нийт}*h*k_c=м3$ $V=20000*1.15*1.05=24150 м3$	$V_{пл1}$ - тэгшлэх ажлын хэмжээ м3 $S_{нийт}$ - тэгшлэх талбай 20000 м3 $h$ - тэгшлэх хөрсний зузаан 150 см $k_c$ - сийрэгжилт тооцох коэффициент 1.05
	Бульдозерийн бүтээл м2/цаг	$S_m=208.8$	24150 м3 хөрсийг хэлбэршүүлэхэд 19 хоног, 152 цаг ажиллана



1	Нийт ажиллах хугацаа	$T=152$	T- тухайн ажлыг хийж гүйцэтгэх хугацаа, 19 хоног, өдөрт 8 цаг, 152 цаг
2	Түлш, ШТМ-ын зардал	$C_{дт}=T \cdot T_{3ц} \cdot 1.15 \cdot P_{дт}=152 \cdot 30 \cdot 1.15 \cdot 2=10488$	$C_{дт}$ - түлш, тосолгооны материалын хэрэгцээ, мян.төг $T_{3ц}$ - цагт зарцуулах түлшний норм 30л, 1.15- тосолгооны материалыг түлшний зардлыг 15-иар тооцов, $P_{дт}$ - 1 литр д/түлшний үнэ 4.0 мян.төг
3	Сэлбэг	$C_{сэ}=XO_{авто} \cdot k \cdot t / T_k=100900 \cdot 0.05 \cdot 152 / 2060=372.3$	$C_{сэ}$ - сэлбэгийн зардал мян.төг $XO_{бульд}$ - машины анхны үнэ k- сэлбэг тооцох анхны үнэ 5%
4	Цалингийн зардал	$C_{ц}=T \cdot Ц_{ц}=152 \cdot 5.68=863.36$	$C_{ц}$ - цалингийн нийт зардал, мян.төг $Ц_{ц}$ - машинист, жолоочийн цагийн тарифт цалин 5.68 мян.төг
5	НДШ	$C_{ндш}=C_{ц} \cdot 0.135=863.36 \cdot 0.135=166.5$	$C_{ндш}$ - цалингийн сангийн 13.5%-иар бодно
6	Элэгдэл, хорогдлын зардал	$C_{эхш}=XO_{бульд} \cdot H_{э} \cdot t / T_k=100900 \cdot 0.1 \cdot 152 / 2060=744.5$	$C_{эхш}$ - элэгдэл хорогдлын шимтгэл мян.төг $H_{э}$ - элэгдэл хорогдлын шимтгэлийн норм, 10% $T_k$ - уурхай ажилд ажиллах нийт хугацаа, 2060 цаг T- хөрсний үеийг хуулах, түрэх хугацаа
Нийт зардал мян.төг		$C_{нийт}=C_{дт}+C_{сэ}+C_{ц}+C_{ндш}+C_{эхш}=10488+372.3+863.36+166.5+744.5=12634.66$	
1 м3 шимт хөрс хуулах өөрийн өртөг		$a=C_{нийт}/V=12634.66/24150=0.523$	a- тухайн техникийн нэгж ажлыг гүйцэтгэх өөрийн өртөг мян.төг/м3

Хүснэгт №14 Бульдозероор 2.0 га талбайг шимт хөрсөөр хучих ажлын зардал

№	Зардлын нэр	Томъёо	Тайлбар
	Тэгшлэх ажлын хэмжээ эзэлхүүн м3, талбай м2	$V_{пл1}=S_{нийт} \cdot h \cdot k_c=м3$ $V=20000 \cdot 0.27 \cdot 1.05=5670 м3$	$V_{пл1}$ - тэгшлэх ажлын хэмжээ м3 $S_{нийт}$ - тэгшлэх талбай 20000 м2 h- тэгшлэх хөрсний зузаан 27 см $k_c$ - сийрэгжилт тооцох коэффициент 1.05
	Бульдозерийн бүтээл м2/цаг	$S_m=200$	5670 м3 шимт хөрс хучих ажилд 3.5 хоног, цагт 200 м3 ажил хийнэ
1	Нийт ажиллах хугацаа	$T=28.4$	T- тухайн ажлыг хийж гүйцэтгэх хугацаа, 3.5 хоног, өдөрт 8 цаг, 28.4 цаг

2	Түлш, ШТМ-ын зардал	$C_{дт} = T * T_{3ц} * 1.15 * P_{дт} = 28.4 * 30 * 1.15 * 2 = 1959.6$	С <sub>дт</sub> - түлш, тосолгооны материалын хэрэгцээ, мян.төг Т <sub>3ц</sub> - цагт зарцуулах түлшний норм 30л, 1.15- тосолгооны материалыг түлшний зардлыг 15-иар тооцов, P <sub>дт</sub> - 1 литр д/түлшний үнэ 4.0 мян.төг
3	Сэлбэг	$C_{сэ} = X_{Обульд} * k * t / T_k = 100900 * 0.05 * 28.4 / 2060 = 69.55$	С <sub>сэ</sub> - сэлбэгийн зардал мян.төг X <sub>Обульд</sub> - машины анхны үнэ k- сэлбэг тооцох анхны үнэ 5%
4	Цалингийн зардал	$C_{ц} = T * Ц_{ц} = 28.4 * 5.68 = 161.31$	С <sub>ц</sub> - цалингийн нийт зардал, мян.төг Ц <sub>ц</sub> - машинист, жолоочийн цагийн тарифт цалин 5.68 мян.төг
5	НДШ	$C_{ндш} = C_{ц} * 0.135 = 161.31 * 0.135 = 21.77$	С <sub>ндш</sub> - цалингийн сангийн 13.5%-иар бодно
6	Элэгдэл, хорогдлын зардал	$C_{эхш} = X_{Обульд} * H_{э} * t / T_k = 100900 * 0.1 * 28.4 / 2060 = 139.1$	С <sub>эхш</sub> - элэгдэл хорогдлын шимтгэл мян.төг H <sub>э</sub> - элэгдэл хорогдлын шимтгэлийн норм, 10% T <sub>к</sub> - уурхай ажилд ажиллах нийт хугацаа, 2060 цаг T- хөрсний үеийг хуулах, түрэх хугацаа
Нийт зардал мян.төг		$C_{нийт} = C_{дт} + C_{сэ} + C_{ц} + C_{ндш} + C_{эхш} = 1959.6 + 69.55 + 161.31 + 21.77 + 139.1 = 2351.33$	
1 м3 шимт хөрс хуулах өөрийн өртөг		$a = C_{нийт} / V = 2351.33 / 5670 = 0.415$	a- тухайн техникийн нэгж ажлыг гүйцэтгэх өөрийн өртөг мян.төг/м3

## 6.2 Биологийн нөхөн сэргээлт

Манай компани нь тусгай зөвшөөрөлтэй талбайн баруун урд овоолгод 2 га талбайд биологийн нөхөн сэргээлт хийнэ. Нөхөн сэргээлтэд дагуурын өлөнгө, ерхөг, согоовор, царгас зэрэг олон наст ургамлын холимог үр тарина. Хуучин мод тарьсан газарт нэмж хайлаас, улиас зэрэг мод сөөг тарина.

Уурхайн биологийн нөхөн сэргээлтийн ажлыг бэлчээрийн зориулалтаар хийж гүйцэтгэнэ. Биологийн нөхөн сэргээлтийн ажилд техникийн нөхөн сэргээлт хийсэн талбайг ургамалжуулахаас гадна хөрсийг бордох, сайжруулах, арчлах, услаж тордох ажлууд багтана.

Биологийн нөхөн сэргээлтийн ажлыг дараах стандартуудын дагуу хийж гүйцэтгэнэ. Үүнд:



- Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн ерөнхий шаардлага MNS:5917:2008
- Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн ерөнхий шаардлага MNS:5918:2008

Биологийн нөхөн сэргээлтээр ургамалжуулах ажлыг зардлыг тооцоо.

$$Z_{ур} = S_{нс} * N_{ур} - P_{ур} * Z_{ц} * T * N + Z_{ус} = 1 * 30 * 40 * 50 * 3 * 8 = 1,440 \text{ мян.төг}$$

$Z_{ур}$ - ургамалжуулах ажлын нийт зардал мян.таг

$S_{нс}$ - биологийн нөхөн сэргээлт хийх талбай 1 га

$N_{ур}$ - 1 га талбайд шаардлагатай ургамлын үрийн норм 30 кг

$P_{ур}$ - 1 кг ургамлын үрийн зах зээлийн үнэ 40 мян.төг

$Z_{ц}$ - нэг ажилчны нэгж хугацааны цалин, хоногт 50 мян.төг

$T$ - ургамалжуулах ажлыг гүйцэтгэх хугацаа 3 хоног

$N$ - шаардлагатай ажилчдын тоо 8 хүн

$Z_{ус}$ - Усалгааны ажлын зардал

Мод тарих ажлын зардлын тооцоо:

$$Z_{ой} = S_{нс} * N_{ой} - P_{мод} * Z_{ц} * T * N + Z_{ус} = 1 * 300 * 7 * 50 * 10 * 8 = 8,400 \text{ мян.төг}$$

$Z_{ой}$ - ойжуулах ажлын зардал мян.төг

$S_{нс}$ - ойжуулах шаардлагатай талбай 1 га

$N_{ой}$ - шаардагдах модны тоо 300 ш

$P_{мод}$ - нэгж модны зах зээлийн үнэ 7,0 мян.төг

$Z_{ц}$ - нэг ажилчны өдрийн цалин 50 мян.төг

$T$ - ойжуулалтаар ажиллах хоног 10 хоног

$N$ - шаардлагатай ажилчдын тоо 8

$Z_{ус}$ - усалгааны ажлын зардал

### 6.3 Нөхөн сэргээлтийн ажлын нийт зардал

Хүснэгт №15 Нийт зардал

№	гүйцэтгэх ажил ба зардлын төрөл	хэмжих нэгж	ашиглах техник	ажлын хэмжээ	нэгж зардал мян.төг	нийт зардал мян.төг
техникийн нөхөн сэргээлт						
1	2.0 га талбайн	га	бульдозер	2.0	0.513	4203.76

	шимт хөрс хуулах, ачих, тээвэрлэх	мян.м3	утгуурт ачигч	8190	0.38	3119.51
		мян.м3	автосамосвал	8190	0.138	1128.11
2	Бульдозероор 2.0 га талбайг хэлбэршүүлэх	мян.м3	бульдозер	13878	0.523	7258.49
3	Бульдозероор 2.0 га талбайг шимт хөрсөөр хучих	мян.м3	бульдозер	5670	0.415	2351.33
техникийн нөхөн сэргээлтийн зардлын дүн		мян.төг	18,061.200			
Биологийн нөхөн сэргээлт						
4	1 га талбайг ургамалжуулах	га	гараар	1	1440	1440
5	1 га талбайг моджуулах	га	гараар	300	28	8400
биологийн нөхөн сэргээлтийн зардлын дүн		мян.төг	9,840.00			
Нөхөн сэргээлтийн ажлын нийт зардлын дүн		мян.төг	27,901.200			

### 7. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ гэж дүйцүүлэн хамгаалахаар тогтоогдсон газар нутагт сонгон авсан биологийн олон янз байдлыг хамгаалах, сайжруулахад чиглэгдсэн хамгааллын менежментийн багц арга хэмжээ юм. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлсний үр дүнд тухайн газрын биологийн олон янз байдал хэвийн нөхцлөөс илүүтэй сайжирсан байх нь дүйцүүлэн хамгааллын эцсийн зорилго болно.

Энэ жил Хэрлэн сумын 10 дугаар багийн гэр хорооллын хойно хуучин хорих ангийн орхигдож эвдэрсэн барилгын суурь 1 га талбайг цэвэрлэж техникийн нөхөн сэргээлт хийхээр төлөвлөв. Энэхүү ажилд нийт ажиллах хүч болон 2 ш утгуурт ачигчийн зардалд 16,727,000 төгрөгийг төсөвлөсөн.

Хүснэгт №16 Дүйцүүлэн хамгааллын ажлын төлөвлөгөө

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал мян, төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8



1	Барилгын суурь талбайг тэгшлэх	Эвдэрсэн газарт техникийн нөхөн сэргээлт хийх	1 га газарт	1	16.727.0	16.727.0	2023 онд	Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт MNS:5914:2008
	Нийт				16.727.0	16.727.0		

Дүйцүүлэн хамгаалалт хийх газрын зургийг хавсралтаар оруулав.

### Төслийн нөлөөлөлд өртөх газрын хэмжээ

- 100 хувь зүүн бүсийн экологийн бүс нутгийн үнэлгээнд багтсан
- 100 хувь Дорнод аймгийн Хэрлэн, Баянтүмэн сумын нутаг дэвсгэр дотор үүсэх нөлөөлөл
- Нөлөөллийн бүсийн
  - Бага нөлөөлөлд 467.2 га
  - Дунд нөлөөлөлд 64.95 га
  - Их нөлөөлөлд 201.52 га

Нийт 733,67 га талбайд нөлөөлөл үзүүлнэ.

### Дүйцүүлэн хамгаалах шаардлагатай газрын хэмжээ

Төслийн нөлөөлөлд өртөх газрын хэмжээг тогтоосны дараагаар төслийн нөлөөллийг дүйцүүлэн хамгаалах шаардлагатай газрын хэмжээг тогтооно. Дүйцүүлэн хамгаалах шаардлагатай газрын хэмжээг тогтооход дараах хүчин зүйлүүдийг харгалзана. Үүнд:

- Экосистемийн ховор байдал
- Амьдрах орчны төрөл
- Экологийн эрүүл байдал
- Ландшафтын байршил
- Нөлөөллийн хугацаа

Дүйцүүлэн хамгаалах шаардлагатай газрын хэмжээг тогтоохдоо эдгээр хүчин зүйл тус бүрээр дараах хүснэгтэд харуулсан дүйцүүлэн хамгааллын итгэлцүүрийг ашиглана.

Хүснэгт №17 Дүйцүүлэн хамгааллын итгэлцүүр

Ангилал	Тодорхойлолт	Дүйцүүлэн хамгааллын итгэлцүүр
<b>Амьдрах орчны ангилал</b>		
Чухал	Экологийн бүс нутгийн үнэлгээгээр экологийн хувьд чухал гэж тогтоогдсон газрууд. Марксан программ тогтоогдсон анхны хувилбар болон давхцал үүссэний дахин боловсруулсан хувилбар орно	3
Хэвийн	Чухал болон өөрчлөгдсөн гэж тогтоогдсон газруудаас бусад	1.5
Өөрчлөгдсөн	ГЗМС дээр тогтоогдсон хүний үйл ажиллагааны нөлөөллийн индексийн утга 95%<бүхий газрууд	0.20
<b>Экосистемийн ховор байдал</b>		
Маш ховор	Эх газрын экосистемийн ангиллаар тухайн экологийн бүс нутаг ба био-газарзүйн мужлалын хэмжээнд <5% тархацтай	3
Ховор	Эх газрын экосистемийн ангиллаар тухайн экологийн бүс нутаг ба био-газарзүйн мужлалын хэмжээнд 5%<-<10% тархацтай	1.5
Хэвийн	Эх газрын экосистемийн ангиллаар тухайн экологийн бүс нутаг ба био-газарзүйн мужлалын хэмжээнд <10% тархацтай	0.20
<b>Экологийн эрүүл байдал</b>		
Сайн	ГЗМС дээр тогтоосон хүний үйл ажиллагааны нөлөөллийн индексийн утга бага байх 0%<50% бүхий газрууд	3
Дунд	ГЗМС дээр тогтоосон хүний үйл ажиллагааны нөлөөллийн индексийн утга 51%<94% бүхий газрууд	1.5
Муу	ГЗМС дээр тогтоосон хүний үйл ажиллагааны нөлөөллийн индексийн утга их байх 95%<бүхий газрууд	0.20
<b>Ландшафтын байршил</b>		
Чухал	Экологийн хувьд чухал ач холбогдолтой газруудын хилээс 20 км-ээс бага зайтай бол Нүүдлийн амьтдын шилжилт хөдөлгөөнд ноцтой саад учруулах	3
Дунд	Экологийн хувьд чухал ач холбогдолтой газруудын хилээс 20 км-50 км бага зайтай бол Нүүдлийн амьтдын шилжилт хөдөлгөөнд зарим талаар саад учруулах	1.5
Чухал бус	Экологийн хувьд чухал ач холбогдолтой газруудын хилээс 50 км-ээс хол зайтай бол Нүүдлийн амьтдын шилжилт хөдөлгөөнд саад учруулахгүй	0.20
<b>Нөлөөлөл үргэлжлэх хугацаа</b>		
>20 жил	Нөхөн сэргээлт бүрэн хийж дуусах хүртэл хугацааг оруулан тооцно	3
5-20 жил		1.5
>5 жил		0.20

Уулын ажил эхэлмэгц харьяа аймаг, сум, багийн иргэд нийтийн хуралд сууж ордын ажлын явцын талаар танилцуулах ба уулын ажил дууссанаас хойш орчны хог хаягдал, бохирдсон талбайг бүрэн цэвэрлэж байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг хуулийн хугацаанд нь гарган



харьяа аймаг, сум, багийн иргэдэд танилцуулах ба, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

### **Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг тодорхойлох**

“Найнги” ХХК-ийн Адуунчулууны нүүрсний уурхайн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний /БОННУ/ ажлын хүрээнд тооцоолсноор нийт 917 га талбайд дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлбэл зохино. Тус дүйцүүлэн хамгааллын ажлын хүрээнд Хэрлэн сумын 8 дугаар баг, Баянтүмэн сумын 4 дүгээр багийн нутаг дэвсгэрт урьд жилүүдэд ашиглалтын үйл ажиллагааны улмаас үүсэж хаягдсан 50 орчим га овоолгыг үе шаттайгаар техникийн нөхөн сэргээлт хийж байгалийн унаган төрхийг бий болгохоор төлөвлөсөн.

### **Дүйцүүлэн хамгааллын зардал**

Биологийн олон янз байдлыг хамгаалах арга хэмжээний төсөвт дараах зардлууд орно. Үүнд:

- Дүйцүүлэн хамгааллын нэмэлт судалгааны зардал (Eг). Энэ нь тухайн жилийн дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах нэмэлт судалгааны шинжилгээний ажил
- Дүйцүүлэн хамгааллын арга хэмжээг төлөвлөх зардал (Eb) нь биологийн олон янз байдлын суурь судалгааны зардал ба дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг талуудын оролцоотойгоор төлөвлөх, төлөвлөгөөг холбогдох байгууллагаар батлуулах арга хэмжээний зардлууд орно.
- Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх зардал (Eo) нь тухайн газар нутагт хэрэгжүүлэх биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан, хэрэгжүүлэх шаардлагатай менежментийн арга хэмжээг санхүүжүүлэх зардлаас бүрдэнэ.

$$E_o = S_o * (C * 1 + r)^t$$

E<sub>o</sub>- Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний нэг жилийн зардал

S<sub>o</sub>- Дүйцүүлэн хамгаалах шаардлагатай талбай (га)=917

C- Дүйцүүлэн хамгаалах нэг га-д ногдох зардал, C=5 т.н

(1+r)<sup>t</sup>- Инфляци=1

$$E_o = 917 \text{ га} * 5 \text{ т.н} * 1 = 4585 \text{ т.н}$$

Нэгж талбайд дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх зардлыг 5 төлбөрийн нэгж гэж үзвэл төслийн нийт 917 га талбайн дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний нэг жилийн зардал 4585 төлбөрийн нэгж болж байна. Журмын дагуу 1 төлбөрийн нэгж нь 1 ам.доллартай тэнцүү гэж үзнэ. Дүйцүүлэн хамгааллын нэгж жилийн зардал=4585\*2850төг=13,067,250.0 төгрөг байна.

Гүйцэтгэгч байгууллагын менежментийн зардал (Em) нь дүйцүүлэн хамгааллын нэмэлт судалгаа, дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг гүйцэтгэх мэргэжлийн зөвлөх үйлчилгээний зардлаас бүрдэнэ. Энэ нь дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх зардлын 20%-иас хэтрэхгүй байна.

Дүйцүүлэн хамгаалах зардлын нийт хэмжээ

$$E_{total}=E_r+E_b+E_o+E_m$$

E<sub>total</sub>- Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний жилийн нийт зардал

Хүснэгт №18 Дүйцүүлэн хамгааллын нийт зардлын хэмжээ

Д/д	Зардлын нэр	Зардлын хэмжээ мян.төг	Тайлбар
1	Er-Дүйцүүлэн хамгааллын нэмэлт судалгааны зардал	1000	Тусгай зөвшөөрөлтэй талбайн урд хэсгийг судлах
2	Eb- Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг төлөвлөх зардал	2000	ДХ-ыг төлөвлөхөд олон нийтийн оролцоог хангах, төлөвлөгөөг холбогдох байгууллагаар батлуулах арга хэмжээний зардал
3	Eo- Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх зардал	11,113.55	"MDT-Mitigation Design Tool" загварчлалаар тооцоолсон дүн
4	Em- Гүйцэтгэгч байгууллагын менежментийн зардал	2,613.45	Нэг жилийн зардал
	<b>Нийт зардал</b>		<b>16,727.000</b>

## 8. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

Төсөл хэрэгжүүлэх талбайн хүрээнд болон төслийн хамгийн их нөлөөлөл бүхий бүсэд суурин айл өрхүүд байхгүй тул одоогоор ямар нэг нүүлгэн шилжүүлэлт, нөхөн олговрын ажил төлөвлөгдөөгүй.



Хүснэгт №19 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

№	Нөлөөлөлд өртөх иргэд	Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн өртөг, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1	Тусгай зөвшөөрөлтэй талбай болон хамгийн их нөлөөлөл бүхий бүсэд суурин айл өрх байхгүй	Ямар нэгэн арга хэмжээ төлөвлөөгүй	-	-	-	-	-	-
	Нийт							

**9. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө**

2013 онд ШУА-ын археологийн хүрээлэнгийн баг археологийн хайгуул судалгаа хийсэн бөгөөд тус судалгаагаар уурхайн орчимд түүх соёлын дурсгалт зүйлс илрээгүй, палентлогийн олдвор байхгүй болохыг тогтоосон. Ашиглалтын явцад уурхайн орчинд түүх соёлын дурсгалт зүйлс, палентлогийн олдвор илэрвэл Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн дагуу шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн:

8.9-д Хуульд өөрөөр заагаагүй бол түүх, соёлын дурсгалт зүйлийг олж илрүүлсэн этгээд энэ тухай холбогдох сум, дүүргийн Засаг даргын тамгын газарт 7 хоногийн дотор мэдэгдэнэ.

17.11-д Иргэн түүх, соёлын дурсгалт зүйлд аюул учирч байгаа, эсхүл учирч болзошгүй байдал олж илрүүлсэн бол энэ тухай холбогдох байгууллага, албан тушаалтанд нэн даруй мэдэгдэх, боломжтой бол хамгаалах арга хэмжээ авах үүрэгтэй.

17.12-д Газрын хэвлийг ашиглах явцад түүх, соёлын дурсгалт зүйл илэрвэл газрын хэвлийг ашиглагч нь ажлаа зогсоож энэ тухай сум, дүүргийн Засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэнэ.

17.13-д Түүх соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийг соёл, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрөлгүйгээр хөдөлгөхийг хориглоно гэсэн заалтуудыг дагаж мөрдөж ажиллана.

Хүснэгт №20 Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1	Археологийн дурсгал	Тусгай зөвшөөрөлтэй талбайгаас археологийн ямар нэгэн илэрц илрээгүй	Үйл ажиллагааны явцад түүх, соёлын олдвор олдсон тохиолдолд хуулийн дагуу ажиллана	-	-	-	-	-
2	Палентологийн дурсгал	Тусгай зөвшөөрөлтэй талбайгаас палентологийн ямар нэгэн илэрц илрээгүй	Үйл ажиллагааны явцад түүх, соёлын олдвор олдсон тохиолдолд хуулийн дагуу ажиллана	-	-	-	-	-
	Нийт							

**10. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө**

Компаний тусгай зөвшөөрөлтэй талбайд байгалийн болон үйл ажиллагааны улмаас үүсэх эрсдэлтэй нөхцөлд

1. Хүчтэй салхи, шуурганы талаарх сэрэмжлүүлэг мэдээг урьдчилан мэдэх
2. Болзошгүй аюул, гамшгийн үед цагийн байдлын талаар мэдээлэл цуглуулах, дамжуулах, холбоо харилцааны техник хэрэгслийг бэлэн байдалд байлгах
3. Гал унтраах хэрэгслийг байнгын бэлэн байдалд байлгах
4. Аюулт үзэгдлийн үед өөрийн болон бусдын эрүүл мэнд, амь насыг хамгаалах, аврах анхан шатны тусламж үзүүлэх мэдлэгтэй болгох
5. Сэрэмжлүүлэг мэдээг байнга хүлээн авч заавар, зөвлөмжийг биелүүлэх
6. Гэр, орон байрнаасаа гарахгүй байх
7. Гал түймрийн аюулаас болгоомжлох, шаардлагатай тохиолдолд цахилгааныг салгах



8. Замд зайлшгүй гарах тохиолдолд техникийн бүрэн бүтэн байдал, шатахууны нөөц, явах зам харгуй, жолоочийн туршлага, ур чадвар зэргийг харгалзан үзэх
9. Хохирол гарсан болон өөрт байгаа мэдээллийг холбогдох байгууллагад мэдээлэх
10. Уурхайн байрлал нь зун намрын улиралд үргэлжилсэн буюу их устай бороо орсноос шалтгаалан үер усны аюул гарч болзошгүй бөгөөд үер уснаас хамгаалах далан, шуудуу, суван татна. Уурхайн босоо, налуу гол амны амсрыг уулын малталт руу гадаргуугийн ус орохооргүйгээр байрлуулж тоноглоно.
11. Уулын ажлын нөлөөгөөр газрын гадаргуу дээр гарсан ан цав, нүх, цөмрөл, уурхайн гүний малталтын дээгүүр байрласан гол мөрний хуурай голдрил, гуу жалгаар дамжин ширүүн бороо, мөндөр, үерийн ус уурхайн малталт руу урсан орохоос хамгаалсан суваг шуудуу татан хааж хамгаална.

Хүснэгт №21 Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээ ний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1	Ажилчдын санаатай болон санамсаргүй үйлдэл, машин, техникийн эвдрэл гэмтэл, доголдлоос гарах	Болзошгүй осол аюулын үед орон нутгийн эмнэлгийн болон бусад холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах	-	-	Хөдөлмөрийн дотоод журам		Жил бүр	MNS4968:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, Эрүүл ахуй Ерөнхий шаардлага
		Ажлын байранд эмнэлгийн анхны тусламж эмийн сантай байх	-	1	ХАБЭА-н чиглэлээр зардал төсөвлөгдсөн		Жил бүр	MNS4969:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, Эрүүл ахуйн сургалтын зохион байгуулалт үндсэн журам
		Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэгслээр хангах	-	1	ХАБЭА-н чиглэлээр зардал төсөвлөгдсөн		Жил бүр	
		Ажилчдыг жил бүр эмнэлгийн үзлэгт хамруулах	-	1	ХАБЭА-н чиглэлээр зардал төсөвлөгдсөн		Жил бүр	

2	Аянга цахилгаан, хэт халалт, гэнэтийн хүчтэй цахилгаан гүйдлийн нөлөөгөөр галын аюул гарах	Галын аюулаас урьдчилан сэргийлэх талаар дүрэм, журмыг шинэчлэн боловсруулж мөрдлөг болгон ажиллах	Тогтмол		Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн багц журам	Өдөр тутам	MNS5390:2004 Цахилгааны галын аюулгүй байдал, Ерөнхий шаардлага
3	Шатах, тослох материалын аюулгүй ажиллагааг хангаагүйг ээс галын аюул гарах	Гал түймрийн үед хэрхэн ажиллах талаар болон аюулгүй ажиллагааны талаар, мөн байгалийн гамшгийн үед хэрхэх талаар ажилчдын дунд сургалт зохион байгуулах	Жилд 1 удаа		Хөдөлмөрийн дотоод журам	жил бүр	MNS5150:2002 Хөдөлмөрийн аюулгүй байдал, үйлдвэрлэлийн эрүүл ахуй, цахилгааны аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага
		Түлш тээвэрлэх, түгээх автомашины бүрэн бүтэн байдалд хяналт тавьж, тодорхой ажилтанд хариуцуулна	Тогтмол		Хөдөлмөрийн дотоод журам	Өдөр тутам	MNS4244:1994 Галын аюулгүй байдал, Ерөнхий шаардлага
	Нийт						

### 11. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Ордын ашиглалттай холбогдож гарах хог хаягдлын хяналт, удирдлага, зохион байгуулалт нь уурхайд одоо мөрдөж байгаа журмын дагуу хийгдэнэ. Энэ нь хог хаягдал, байгаль орчны талаархи Монгол улсын хууль, бодлого шийдвэр, дүрэм журмын дагуу, олон улсын уул уурхайн үйл ажиллагаанд шалгарсан дэвшилтэт арга технологиор хийгдэж байгаа юм. Ордын ашиглалтын үйл ажиллагаанаас хатуу хог хаягдал гарахгүй, тэнд ажиллагсдаас гарах ахуйн хог хаягдлыг нэгдсэн журмаар “Чойбалсан хөгжил” ОНӨААТҮГ-тай байгуулсан гэрээгээр төв хогийн цэгт хүргүүлнэ.

Аюултай хог хаягдлын үүссэн болон хуримтлагдсан хэмжээг нэр, төрөл бүрээр бүртгэж, жил бүрийн 12 дугаар сарын 15-ны дотор батлагдсан маягт, загварын дагуу тайланг сумын Засаг дарга, аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газарт цахимаар болон цаасаар хүргүүлнэ.



Уул уурхайн тоног төхөөрөмжөөс гарах нефтийн бүтээгдэхүүний үлдэгдэл хаягдлыг нефтийн бүтээгдэхүүнээр ажилладаг зууханд гэрээ байгуулан нийлүүлнэ. Уулын ажилд химийн хортой, аюултай бодис ашиглахгүй.

Нүүрсний хаягдал бохирдлыг хөрсний овоолгоор дарж булна.

Хүснэгт №22 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1	Ахуйн	"Чойбалсан хөгжил" ОНӨААТҮГ-тай байгуулсан гэрээгээр аймгийн төв хогийн цэгт төвлөрүүлнэ	Уурхайн хэмжээнд	тн	50,000	24	1,200,000	Сард 2 удаа	гэрээгээр
2	Үйлдвэрийн	Нүүрсний мөргөцгийн ул, таазны хаягдал	Уулын ажлын хүрээнд	-	-	-	-	-	
3	Аюултай	Ажилласан тос масло	Уулын ажлын хүрээнд	тн	2	-	-	Улирал бүр	гэрээгээр
	Нийт						1,200,000		

## 12. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт ажлыг гэрээгээр мэргэжлийн байгууллагын итгэмжлэгдсэн лабораториор хийлгэхээр төлөвлөсөн.

### Агаар орчны бохирдол

Уурхайн ашиглалтын хугацаанд агаар орчныг бохирдуулагч гол эх үүсвэр нь хөрс хуулалт, нүүрс олборлолт, овоолго байгуулах, нүүрс тээвэрлэлтийн үеийн тоосжилт, машин техникээс гарах утаа тортог орно. Ийм хуурайшилттай үед уурхайн дотоод замыг тогтмол услах техникийн бүрэн бүтэн байдалд байнгын хяналт тавьж агаар бохирдуулалтыг багасгаж ажиллана.

Агаарын чанар физик нөлөөллийн мониторингийг агаарын чанар физик нөлөөллийг уурхайн орчноос сорьц авч уурхай ашиглалт явуулж байгаа үед улиралд 1 удаа шинжлүүлнэ. Энэ зардалд 200,000 төгрөг төсөвлөсөн

Орчны агаарын бохирдлын үндсэн үзүүлэлт болох тоосжилт, нүүрсний өөрөө шаталт болон агаар дахь CO<sub>2</sub>, NO<sub>2</sub>, SO<sub>2</sub>, SPM, CH<sub>2</sub>-ийн цацраг идэвхийн агууламжийг тодорхойлуулна. Агаарын тоосжилт болон цацраг идэвхийн агууламж өндөр байж болох уурхайн ашиглалтын талбай, авто замын орчинд сорьц авч шинжлүүлнэ.

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу агаар, ус, хөрс, ургамлын нөмрөгт хийлгэсэн шинжилгээний дүнд тулгуурлан мониторинг хийж, шинжилгээний дүн тус бүрийг дүгнэлттэй болгох, шинжилгээний дээж авах ажилд хөндлөнгийн хяналтаар сумын байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагчийг байнга байлгах ажлыг зохион байгуулна.

### **Хөрсний бохирдол**

Газрын гадарга болон хэвлийд үзүүлэх нөлөөллийг бууруулах талаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

- Ашиглалтын явцад тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг тогтсон нэг маршрутын дагуу явуулах, МУ-ын стандартын дагуу замын уулзвар, салаалалт дээр тэмдэгжүүлэх
- Хөрсний овоолгыг салхинд хийсэж, тоос шороо дэгдэхээс урьдчилан сэргийлж, тэгшилж, нягтруулж ажиллана.
- Үржил шимт хөрсний алдагдал, өгөршлийг бууруулахын тулд хөрсний овоолгыг ургамалжуулна.
- Хөрсний хяналтын цэгүүдэд жилд 1 удаа мэргэжлийн байгууллагаар хөндлөнгийн хяналт, шинжилгээ хийлгэж, шимт чанар ба бохирдлын хэмжээг тодорхойлуулна.

### **Усны бохирдол**

Төслийн үйл ажиллагааны явцад усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, тэдгээр нөлөөллийг бууруулах зорилгоор доор дурьдсан арга хэмжээг үйл ажиллагааны туршид авч хэрэгжүүлнэ.



- Хур тунадасны ус ялангуяа хүчтэй аадар борооны үед шатах тослох материал болон ахуйн хаяглал хогийг урсган ойр орчмын усан орчин, сайр голдиролд орж бохирдуулах нөхцөлөөс урьдчилан сэргийлэх
- Уурхайн шүүрлийн ус цуглуулах талбайд цугларсан усанд улиралд 1 удаа мэргэжлийн байгууллагаар шинжилгээ хийлгэнэ.
- Шатах тослох материал бусад хортой аюултай бодис алдагдах, асгарах үед авах яаралтай арга хэмжээг урьдчилан тодорхойлж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах

### Ургамлын мониторинг

Уурхайн ашиглалт хийгдээгүй талбайн ургамлын бүрхэвчийн доройтуулахгүй ажиллах бөгөөд салаа зам гаргахгүй, уурхайн ахилтанд өртөөгүй талбайн ургамлан нөмрөгийг хамгаалах зорилгоор далан байгуулж машин техник явуулахгүй байхаар төлөвлөсөн бөгөөд улиралд 1 удаа ургамлын мониторингийг мэргэжлийн байгууллагаар хийлгэхээр төлөвлөсөн.

### Амьтны мониторинг

Энэхүү төслөөс амьтны аймагт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллүүдийг арилгах, бууруулах дараах арга хэмжээг авна.

- Уулын малталт, овоолгыг зэрлэг амьтдад аюулгүй байхаар байрлуулах
- Ан амьтны тухай хууль, тогтоомжийг чандлан биелүүлж ажиллах
- Төслийн талбай болон ойр орчмын талбайд зэрлэг амьтдын мониторингийг жилд нэг удаа хийх

Хүснэгт №23 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт ажлын төлөвлөгөө

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
Агаарын чанар								
1	Тоосжилт	Тээврийн зам дагуу	Улиралд 1 удаа	1	200,000	200,000		MNS3113:1981 Агаар мандлын бохирдлыг хэмжих аргачлалын ерөнхий шаардлага
Усны чанар								
2	Газрын гүний усны бохирдол	Ус цуглуулах талбайд	Улиралд 1 удаа	1	200,000	200,000		MNS3936:1986 Ундны ус болон үйлдвэрийн ус тухайн талбарт нь шинжилгээ хийх

Хөрсний чанар							
3	Хөрсний ялзмаг болон хүнд металлын бохирдол	Уурхайн ахилтанд өртөөгүй талбай	улиралд 1 удаа	1	200,000	200,000	MNS3298:1991 Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлага
Ургамлын чанар							
4	Ургамлын нөмрөгт үзүүлэх бохирдол	Уурхайн орчинд	Улиралд 1 удаа	1	200,000	200,000	MNS5917:2008
Нийт						800,000	

### 13. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Удирдлага зохион байгуулалтыг сайжруулах нь БОМТ-ний хэрэгжилтийн баталгааг бий болгож буй хэлбэр гэж ихээхэн ач холбогдол өгөх ёстой. БОМТ-ний хэрэгжилтийг хангахад зөвхөн байгаль орчны мэргэжилтэн бус бусад алба, хэлтэс, нэгжийн ажилтнуудын оролцоо шаардагддаг. Тус дэд төлөвлөгөөгөөр Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт оролцооны хэлбэр, тодорхойлон хэрэгжилтийг хангах зорилтуудыг дэвшүүлнэ.


Байгаль орчны мэргэжилтэн техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажлын явц, үр дүнд байнгын хяналт тавих үүрэгтэй

Байгаль орчны мэргэжилтэн, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн инженер нар нь дараахь ажлуудыг гүйцэтгэнэ.

- Байгаль орчны чиглэлийн бараа, ажил, үйлчилгээний техникийн тодорхойлолт, ажлын даалгавар боловсруулах
- Байгаль орчны чиглэлийн журам, горим, зураг төсөл, дэд төлөвлөгөө боловсруулах
- Захиалгат судалгааны ажилд хяналт тавих



- Компаний дотоодод тайлагнах
- Мэдээллийн сан, файлын сантай ажиллах
- Байгаль орчны бүтээн байгуулалтыг зохион байгуулах
- Тариалалт, усалгаа, арчилгааг зохион байгуулах
- Ажлын байрны үзлэг хийх, ажлын байрны зураг авалт хийх
- Туршилт, хяналт шинжилгээ хийх
- Оролцогч талуудад тайлагнах
- Уул уурхайн Байгаль орчны чиглэлийн хурал цуглаанд оролцох
- Мод тарих, зүлэгжүүлэх, мод үржүүлгийн талбай байгуулах
- Тарьц ургамлын арчилгаа, усалгаа хийх
- Багаж төхөөрөмж, нөхөн сэргээлтийн техникийн хэвийн үйл ажиллагааг хангах
- Агуулах, түр хадгалах байрны эмх цэгцийг сахиулах



Хүснэгт 24 Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь	Хариуцсан албан тушаал	тайлбар
1	2	3	4	5
Боломжит нөөцийн ус ашиглуулах дүгнэлт гаргуулах	-	2023 онд	"Найнги" ХХК-ийн Байгаль орчны нэгж	Засгийн Газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны Газраас авах ажлыг зохион байгуулна.
Хэрлэн голын сав газрын захиргаанаас ус ашиглуулах дүгнэлт гаргуулах	-	2023 онд		Усны тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан хүсэлт гаргана.
Мод тарих үндэсний өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх	1.000.000	2023 онд		Мод тарих үйл ажиллагааг зохион байгуулан тэмдэглэнэ.
Хог хаягдлын менежментийг сайжруулах чиглэлээр сургалт зохион байгуулах	200.000	2023 онд		Компанийн нийт ажилчдыг сургалтанд хамруулна.
БОМТ батлагдсан даруйд аймгийн БОАЖГ, сумын Засаг дарга нарт хүргэх, тайлагнах	-	2023 онд		Албан бичгээр хүсэлт хүргүүлнэ.
Орчны хяналт шинжилгээний дээж авах ажилд хөндлөнгийн хяналтаар сумын БОХУБ, Байгаль хамгаалчийг оролцуулах	-	2023 онд		
	<b>1.200.000</b>			



**14. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө**

Хүснэгт 25 Тайлагнах төлөвлөгөө

№	БОХТ-ны биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, мян.төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулсан газар
